

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Н.ЭРДЭНЭБАЯР




“Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв”-д цусны бүлэг тодорхойлох оношлуур
нийлүүлэх шууд гэрээ.

НИЙЛҮҮЛЭГЧ:

МОНОСФАРМ ТРЕЙД ХХК-ИЙН
УЛААНБААТАЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д. ЦЭРЭНБАТ



2016 оны 3 сарын 29

Улаанбаатар хот

Нэг талаас *Цус сэлбэлт судлалын үндэсний төв* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *Монос фарм трейд ХХК* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 03 сарын 29-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогdon захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2 Захиалагч нь “R-Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төвд цусны хүүдий, оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 2016 он 03” дугаартай тендерийн “Цусны бүлэг тодорхойлох оношлуур”-ын 1-р багцын (цаашид “бараа” гэх) нийт 19,580,000 (арван есөн сая таван зуун наян мянган) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.3 Захиалагч нь барааны нийлүүлэлтийг нийт 19,580,000 төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 1.4 Нийлүүлэгч нь барааг 2016 оны 04 дугаар сарын 15-наас 2016 оны 9 дүгээр сарын 01-ний дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- 1.5 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 1.5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

- 1.5.2 Бусад шаардлагатай баримт бичиг¹;
- 1.5.3 Тендер ба үнийн хуваарь;
- 1.5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 1.5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 1.5.6 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 1.5.7 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 1.6 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- 1.7 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 1.8 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

- 2.1. Захиалагч нь 1.4-т дурдсан хугацаанд нийлүүлэгдсэн барааг хүлээн авч, хүлээн авсан тухай баримт бичиг болон нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 20 хоногийн дотор төлбөрийг нийлүүлэгчийн данс руу шилжүүлэх үүрэгтэй.
- 2.2. Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжилсэн нийт үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх алдангийг хэтрүүлсэн хоног тутамд нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.
- 2.3. Захиалагч нь нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй, эсвэл нийлүүлэгч нь гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлах үүрэгтэй.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

- 3.1. Нийлүүлэгч нь гэрээний бүх нөхцөл, техникийн тодорхойлолтонд нийцсэн барааг нийлүүлэх үүрэгтэй.
- 3.2 Барааны шошго нь тендерийн материалд заасны дагуу англи хэл дээр бичигдсэн байна.
- 3.3. Нийлүүлэгч нь барааг шаардлагын дагуу зөв тээвэрлэн хургэх нөхцөлийг хангах асуудлыг бүрэн хариуцана.
- 3.4. Нийлүүлэгч нь барааны тоо хэмжээг дутаах, нийлүүлэх хугацааг хоцроо асуудал гаргасан тохиолдолд гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр хоногийн 0,1%-ийн алдангийг захиалагчид төлнө.

Дөрөв. Хүчинтэй хугацаа

Гэрээ нь нийлүүлэгч барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг дансаар хүлээн авч дуусах хүртэл хүчинтэй байна.

Тав. Бусад зүйл

- 5.1. Талууд гэрээнд холбогдох асуудлаар албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
- 5.2. Гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэх ба зөвшилцэх боломжгүй болсон тохиолдолд ХАҮТ-ын дэргэдэх арбитрын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Уг гэрээ нь монгол хэл дээр З хувь хийгдсэн ба талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчинтэй болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний

Төвийн Ерөнхий нягтлан бодлоги Д.Гүнжээ



Хаяг: Сүхбаатар дүүрэг, Энхтайваны
өргөн чөлөө-13, С.Зоригийн гудамж

Утас: 326504, 312857, Факс: 976-11- 312857

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :

Монос фарм трейд ХХК-ийн

Менежер Ц.Амарбаясгалан



MONOS FARM

ТРЕЙД

Хаяг: Баянзүрх дүүрэг Намъянжугийн
Утас: 450054/113/, Факс: 463158

Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж барааны үнийн хуваар

0ГН00: 2016.03.29

ХТШ-ЫН ДУГААР : 2016 ОН 03

БАГЦ 2. ЦУСНЫ БҮЛЭГ ТОДОРХАЙЛОХ ОНОШЛУУР

| № | Бүтээгдэхүүний нэр | Түн | Үйлдвэрлэсэн компани | Гарал үүслийн улс | Тоо ширхэг | СИП нийт нэгж үнэ ₮ | Нэр төрлийн нийт дун ₮ |
|---|--------------------|------|----------------------|-------------------|------------|---------------------|------------------------|
| 1 | Анти А | 10мл | Ренам, гематологи | ОХУ | 550 | 5000 | 2750000 |
| 2 | Анти В | 10мл | Ренам, гематологи | ОХУ | 550 | 5000 | 2750000 |
| 3 | Анти Д | 10мл | Ренам, гематологи | ОХУ | 680 | 11000 | 7480000 |
| 4 | Анти келл | 5 мл | Ренам, гематологи | ОХУ | 550 | 12000 | 6600000 |
| | Дун | | | | | | 19580000 |

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТНИЙ ХУВААРЬ ЦУСНЫ БҮЛЭГ ТОДОРХОЙЛОХ ОНОШЛУУРЫН БАГЦ №2

| | Бүтээгдэхүүний нэр | Олон улсын буоу өрөнхий нэршил | Эмийн хэлбэр | Савалтын хэмжээ | Шаардагдаж буй хэмжээ | Нийлүүлэлтийн хувваарь |
|---|---------------------------|---|-------------------------|----------------------------------|----------------------------------|-------------------------------|
| 1 | Анти A | Anti A | Оношлуур | 1 флакондоо 10 мл-ээр савлагдсан | 550 фл | 200 |
| 2 | Анти B | Anti B | Оношлуур | 1 флакондоо 10 мл-ээр савлагдсан | 550 фл | 200 |
| 3 | Анти D | Anti D | Оношлуур | 1 флакондоо 10 мл-ээр савлагдсан | 680 фл | 380 |
| 4 | Анти көлл | Anti K | Оношлуур | 1 флакондоо 5 мл-ээр савлагдсан | 550 фл | 100 |